



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар Б/22

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.2, 3.2.6, 4.1, 4.9, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүүхэд асрах чөлөөтэй байгаа Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежер Д.Зоригтбаясгалангийн ажил үүргийг гүйцэтгэн түр томилогдон ажиллаж байсан Н.Нямсүрэн нь өөр ажилд шилжин ажиллах болсон тул 2017 оны 1 дүгээр сарын 30-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Өлзийбаярын Өлзийцэцэгийг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс Д.Зоригтбаясгаланг ажилдаа эргэн томилогдох хүртэлх хугацаагаар Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

Гурав. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Ганболд -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Ч.Болормаа -Архив, бичиг хэргийн эрхлэгч
Л.Очирмаа -Аж ахуйн нярав

Дөрөв. Ө.Өлзийцэцэгийн цалинг ТЗ-7-1 шатлалаар буюу 591218 /таван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун арван найман/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

Тав. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежерийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ө.Өлзийцэцэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА